

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ДАРГА НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлд:


“I. Монгол Улсын Засгийн газраас зарласан “Хариуцлагын жил”-ийн хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөгөө гарган, шилэн дансанд байршуулах замаар 2019 оны I улиралд багтаан олон нийтэд ил тод, шуурхай зохион байгуулах;
2. Төрийн болон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагууд баталсан дүрэм, журамдаа шинжилгээ хийж, иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн, байгууллага, иргэдэд хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа дүрэм, журмыг хүчингүй болгох арга хэмжээ авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдээг хагас, бүтэн жилээр ирүүлэх;
3. Төрийн байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй төрийн албан хаагч, албан тушаалтанд хариуцлага тооцож, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээнд тусгаж байх;
4. Төрийн албан хаагч ажлын болон ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох талаар тогтоосон дэг журмыг чанд мөрдүүлэх, журмыг зөрчсөн албан хаагчтай тухай бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож байх;
5. Яам, агентлагийн бодлого, шийдвэрийг бусад байгууллага болон олон нийтэд ил тод мэдээлэх, тусгай зөвшөөрөл олгох ажлыг цахимжуулах арга хэмжээ авах;
6. Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар бүр дүгнэж ажиллах;
7. Төрийн бүх шатны байгууллагын салбар, нэгжийн ажлын уялдаа, бүтээмжийн үнэлгээг тодорхой болгох;

8. Төрийн албан хаагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулах, хууль зөрчсөн албан хаагчдад заавал хариуцлага тооцож байх;

9. Төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын ажлын үр дүнг иргэдийн сэтгэл ханамжийн үзүүлэлттэй холбон дүгнэх үнэлгээний журам тогтоох.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР